

В. Бүтээгдэхүүний тодорхойлолтод оруулсан өөрчлөлт, үнэ

В.1 Тодорхойлолтод оруулсан өөрчлөлт

| Бүтээгдэхүүний нэр төрөл | Код | Өөрчлөлт оруулсан огноо | Оруулсан өөрчлөлт | Уг өөрчлөлт нэгжийн үнэд нөлөөлсөн эсэх (тийм-1, үгүй-2) | Тодорхойлолт өөрчлөгдсөний дараах үнэ (төгрөгөөр) |
|--------------------------|-----|-------------------------|-------------------|--|---|
| А | Б | В | Г | Д | 1 |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

В.2 Тодорхойлолтыг өөрчлөхгүйгээр үнэд оруулсан өөрчлөлт

| Бүтээгдэхүүний нэр төрөл | Код | Өөрчлөлт оруулсан огноо | Өөрчлөгдсөн үнэ (төгрөгөөр) | Үнэ өөрчлөгдсөн шалтгаан* | | | | | |
|--------------------------|-----|-------------------------|-----------------------------|---|---|---|---|---|---|
| | | | | /Доорх кодоос хамгийн их н өлөө үзүүлсэн аль нэг кодыг дугуйлна уу/ | | | | | |
| А | Б | В | 1 | Д | | | | | |
| | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

*Үнэ өөрчлөгдсөн шалтгааны код:

- 1 Материалын зардал нэмэгдсэн/буурснаас
- 2 Хөдөлмөрийн зардал нэмэгдсэн/буурснаас
- 3 Зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, өрсөлдөөний хүчин зүйлийн нөлөөнөөс
- 4 Худалдааны нөхцөл өөрчлөгдснөөс
- 5 Борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үнэд өөрчлөлт оруулах
- 6 Бусад..... /тодорхойлж бичнэ үү/

Дарга /захирал, эзэн// /

Тамга Ерөнхий (ахлах) нягтлан бодогч/ /

Эдийн засагч...../ /

20... оны ... сарын ...

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН 20... ОНЫ ...-Р САРЫН

МЭДЭЭ (АУСУ-1)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Үйлдвэрлэгчийн үнийн мэдээнд хамрагдахаар сонгогдсон аж ахуйн нэгжүүд сонгогдсон бүтээгдэхүүний нэр төрлийн тодорхойлолтод тохирсон бүтээгдэхүүний үнийг тогтоосон хугацаанд, маягтын дагуу үнэн зөв гаргаж мэдээлнэ.

ҮСХ нь ирүүлсэн мэдээг статистикийн үйл ажиллагаанд ашиглах бөгөөд мэдээллийн нууцыг “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу чандлан хадгална.

А. Хаягийн хэсэг

- **Регистрийн дугаар.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад Улсын бүртгэлийн Ерөнхий газар /УБЕГ/-аас олгосон 7 орон бүхий регистрийн дугаарыг нөхнө.
- **Аймаг, нийслэл, сум, дүүрэг.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг нөхнө.
- **Аж ахуйн нэгж, байгууллагын нэр.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг нөхнө.
- **Үйл ажиллагааны салбарын чиглэл.** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” /ЭЗБТУАСА/-ын 4 оронгийн түвшний кодыг нөхнө.
- Кодыг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын ажилтан нөхнө.

Б. Үнийн мэдээлэл

Мэдээнд хамрагдах бүтээгдэхүүний нэрийг Үндэсний статистикийн хорооноос нэр зааж тодорхойлж өгнө. Сонгогдсон бүтээгдэхүүний борлуулалтад 70.0-аас дээш хувийн жин эзэлдэг нэр төрлийн үйлдвэрлэгчийн үнийг маягтын Үнийн мэдээлэл хэсэгт гаргана.

А, Б багананд бүтээгдэхүүний нэр төрлийг бүртгэнэ. Жишээ нь талхийг бүртгэхэд маягтын төрөл хэсэгт талх, нэр төрөл хэсэгт Атар талх, Нийслэл талх, Өргөө талх гэж бичнэ.

В багананд бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА)-аар бүтээгдэхүүний, кодыг нөхнө.

Г багананд бүтээгдэхүүний тодорхойлолтод түүний борлуулалтын үнэд нөлөөлж байгаа бүх үзүүлэлтүүд (холбогдох техникийн үзүүлэлтүүд, хийц, загвар, онцлог), түүнчлэн хэмжих нэгж, савласан төрөл, худалдах нөхцөл (тухайлбал: хүргэж өгөх, төлбөрийг тодорхой хугацаанд хийх) зэрэг үзүүлэлтүүд тусгагдана.

В, Г багананд бүтээгдэхүүний нэр төрлийн тодорхойлолтыг ҮСХ-оос бичнэ.

Д багананд бүтээгдэхүүний хэмжих нэгжийг нөхнө. Жишээ нь ш, кг, мл, гр, тн, л, боодол, хайрцаг гэх мэт.

"1" багананд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийг нөхнө.

Аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгийг багтаасан үйлдвэрийн газрын үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татаасыг оруулж тооцох ба шууд бус татварыг оруулахгүй. Шууд бус татварт гаалийн татвар, онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар зэргийг хамруулан ойлгоно.

Үйлдвэрлэгчийн үнийг сар бүрийн 15-ны өдрийн үнээр авна. Тухайн сарын 15-ны өдөр Бямба гаригт таарвал өмнөх Баасан гаригт шилжүүлэх, Ням гаригт таарвал дараагийн өдөр буюу Даваа гаригийн үнээр гаргана.

Бүтээгдэхүүний үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Жишээ нь: А компанийн Б бүтээгдэхүүн "Үйлдвэрлэгчийн үнийн 2015 оны 1-р сарын мэдээ"-нд хамрагдахаар сонгогдсон гээ. Б бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ 2015 оны 1-р сарын 15-ны өдөр 1500 төгрөг байсан бол маягтын үнийг хэсгийг 1500 төгрөг гэсэн байдлаар нөхнө.

Хэрэв бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ төгрөгөөр илэрхийлэгддэггүй, гадаад улсын валютаар илэрхийлэгддэг бол тухайн сарын 15-ны өдрийн Монгол банкны ханшаар тооцож төгрөгт шилжүүлнэ. Мэдээ гаргах өдрийг амралтын өдөр таарч, шилжүүлсэн тохиолдолд валютын ханшийг шилжүүлсэн өдрийн ханшаар авна.

Багана А, Б, В, Г, Д буюу бүтээгдэхүүний төрөл, нэр, код, тодорхойлолт, хэмжих нэгжийг ҮСХ-ноос урьдчилан бэлтгэж, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар тэдгээр үзүүлэлтүүдийг нөхөж ААНБ-д хүргүүлнэ. ААНБ нь багана "1" буюу бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийг нөхнө.

В. Үнэ, тодорхойлолтын өөрчлөлтийн мэдээлэл

Тод хараар хүрээлсэн хэсгийг аж ахуйн нэгж, байгууллага нөхнө.

В1. Тодорхойлолтод оруулсан өөрчлөлт:

Бүтээгдэхүүний үнийг судлах явцад уг бүтээгдэхүүний нэр төрлийн тодорхойлолтод бичигдсэн тодорхойлолтын аль нэгд өөрчлөлт оруулсан эсвэл тухайн бүтээгдэхүүний хувьд шинэ сав, баглаатай болох, савлагааны хэмжээ, техникийн болон загварын тодорхойлолт нь өөрчлөгдөх зэрэг чанарын зарим өөрчлөлт гарсан бол маягтын В1 хэсгийг нөхнө.

Бүтээгдэхүүний тодорхойлолтод өөрчлөлт оруулсан сар, өдрийг маягтын "Өөрчлөлт оруулсан огноо" баганад, уг өөрчлөлт үнэд нөлөөлсөн эсэх талаар тийм бол 1, үгүй бол 2 гэж маягтын "уг өөрчлөлт үнэд нөлөөлсөн эсэх" багананд хариулна. Мөн түүнчлэн тодорхойлолт өөрчлөгдсөний дараахь шинэ үнийг маягтын дараагийн баганад бичнэ. Кодын баганыг аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтэс, газрын ажилтнууд бичнэ.

В2. Тодорхойлолт өөрчлөгдөлгүйгээр үнэд оруулсан өөрчлөлт:

Бүтээгдэхүүний үнийг судлах явцад уг бүтээгдэхүүний нэр төрлийн тодорхойлолтод бичигдсэн тодорхойлолтын аль нэгд өөрчлөлт оролгүйгээр түүхий эд, материал, хөдөлмөрийн зардал өөрчлөгдөх, зах зээлийн эрэлт нийлүүлэлт, өрсөлдөөний хүчин зүйлс зэргээс шалтгаалж тухайн бүтээгдэхүүний үнэд өөрчлөлт оруулсан бол маягтын В2 хэсгийг бөглөнө. Бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдсөн сар, өдрийг маягтын "Өөрчлөлт оруулсан огноо" баганад, үнэ өөрчлөгдсөний дараахь шинэ үнийг маягтын "Өөрчлөгдсөн шинэ үнэ" баганад бичнэ. Кодын баганыг аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтэс, газрын ажилтнууд бичнэ.

Үнэ өөрчлөгдсөн шалтгаан баганад дараах шалтгаануудаас хамгийн их нөлөө үзүүлсэн нэг шалтгааны кодыг тухайн баганад бичнэ.

- Бүтээгдэхүүний материалын зардал нэмэгдсэн эсвэл буурснаас бүтээгдэхүүний нэр төрлийн үнэд өөрчлөлт орсон бол 1 кодыг,
- Шууд хөдөлмөрийн зардал буюу цалин хөлс, хөдөлмөрийн зардал нэмэгдсэн эсвэл буурснаас бүтээгдэхүүний нэр төрлийн үнэд өөрчлөлт орсон бол 2 кодыг,
- Зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, өрсөлдөөний хүчин зүйлийн нөлөөнөөс бүтээгдэхүүний нэр төрлийн үнийн өөрчлөлтөд нөлөө үзүүлсэн бол 3 кодыг,
- Худалдааны нөхцөл өөрчлөгдснөөс бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийн үнэд өөрчлөлт орсон бол 4 кодыг,
- Тухайн компани борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор бүтээгдэхүүний нэр төрлийн үнэд өөрчлөлт оруулсан тохиолдолд 5 кодыг,
- Бүтээгдэхүүний нэр төрлийн үнийн өөрчлөлтөд нөлөө үзүүлсэн, дээр дурдсан 5 шалтгаанаас өөр шалтгаантай бол 6 кодыг бичиж, шалтгааныг тодорхойлон бичнэ.

Үндэсний статистикийн хороо,

Эдийн засгийн статистикийн хэлтэс

Холбоо барих утас: 261563